



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Номгон

“Хоггүй орчинд амьдаръя”
жил болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын 2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1 дүгээр зүйлийн 6.1.12 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2023 оныг “Хоггүй орчинд амьдаръя” жил болгон зарласугай.

2.“Хоггүй орчинд амьдаръя” жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг чанартай зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Хүрэлсүх)-д үүрэг болгосугай.

3.Жилийн ажлын хүрээнд хийгдэх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахад шаардагдах 15.000,000 (арван таван сая) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга, Төсвийн шууд захирагч (Г.Хүрэлсүх)-д зөвшөөрсүгэй.

4.Зохион байгуулсан ажлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажилд хариуцлагатай хандаж ажиллахыг Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан ажилтан (Г.Сувданцэцэг), Орон нутгийн телевизийн захирал нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (С.Батцэрэн)-д даалгасугай.

ДАРГА

Г.ЭНХБАЯР

Захирамж 2023 он

6:1010791